



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 430

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалттын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалттын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан нийт 84,000,000.00 /наян дөрвөн сая/ төгрөгийн балансын үнэ, 39,033,333.20 /гучин есөн сая гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг хорин мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийд балансаас балансад шилжүүлсүгэй.


2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалттын газрын Захиргаа, удирдлагын албаны дарга Л.Сарнай, “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Батсүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

900795

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн
430дугаар тогтоолын хавсралт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компанид
балансаас балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Форд танзит, 76-91 OPX, арал № WFOAXX6BVASK944 99	1996/ 2015	49,000,000.00	23,449,999.85	25,550,000.15
2	Форд танзит машины чиргүүл, 42-22 ГЧ	1999/ 2013	35,000,000.00	15,583,333.35	19,416,666.65
	Нийт дүн		84,000,000.00 /наян дөрвөн сая/	39,033,333.20 /гучин есөн сая гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг хорин мөнгө/	44,966,666.80 /дөчин дөрвөн сая есөн зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг наян мөнгө/